



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: Монголбанкинд минибус (mini van) нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: CR-2014/03

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчоос ажлын хэрэгцээнд зориулан минибус (mini van) нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн бичиг баримтыг бичгээр хвсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000.00 (тавин мянган) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 (дансны нэр: тендерийн хороо) тоот дансанд тушаана. Тендер нь тvvнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хвчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:
Борлуулалтын хэмжээ: 300,000,000.00 төгрөг,
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 300,000,000.00 төгрөг,
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2013, 2012 он.
Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 2 (хоёр) хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дvнтэй тендерийн баталгаа ирvвлнэ. Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрнө.

Тендерийг 2014 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирvвлэх ба нээлтэд оролцох хвсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2014 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МОНГОЛБАНК

*Бага тойруу -3, 15160, Улаанбаатар хот,
Монголбанкны "А" байрны 1 давхар 2 тоот өрөө,
Утас: 310633, 327048, Факс: 311471*